



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/284

Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах  
тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.“Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн ёс зүйн дүрэм”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Дүрэм батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 172 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.


3.Дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гадаадын иргэн, харьяатын газрын дарга /Н.Ууганбаяр/-д даалгасугай.



Х.НЯМБААТАР

151601079

2022... оны 10 дугаар сарын 22 -ны өдрийн  
1128 дугаар тушаалын хавсралт



## ГАДААДЫН ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн /цаашид “улсын байцаагч” гэх/ ёс зүйн дүрэм /цаашид “дүрэм” гэх/-ийн зорилго нь улсын байцаагчийн хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг тогтоох, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Улсын байцаагч нь үйл ажиллагаандаа Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, энэхүү дүрмийг баримтална.

### Хоёр.Улсын байцаагчийн баримтлах зарчим

2.1.Улсын байцаагч үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

- 2.1.1.хүний эрх, хууль, шударга ёсыг дээдлэх;
- 2.1.2.ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;
- 2.1.3.захирах, захирагдах ёсыг сахин биелүүлэх.

### Гурав.Улсын байцаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээ, хориглох зүйл

3.1.Улсын байцаагч үйл ажиллагаандаа дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална:

3.1.1.албан үүргээ хэрэгжүүлэхдээ хүний нэр төрийг хүндэтгэж, иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн, шударга зан үйлийг эрхэмлэн, хүнлэг энэрэнгүй байх;

3.1.2.хувийн болон нийгмийн харилцаанд нэр төртэй, үнэнч, зарчимч, хүндлэл төрүүлэхүйц байдлыг эрхэмлэх;

3.1.3.хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцахдаа хувийн итгэл үнэмшил, үзэл бодлоо илэрхийлэхээс зайлсхийх;

3.1.4.байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг чанд сахин биелүүлэх;

3.1.5.хууль тогтоомжоор оногдуулсан албан үүргээ зохих ёсоор биелүүлэх иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хуульд заасан хугацаанд түргэн

шуурхай шийдвэрлэх, албан үүргээ хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай мэдлэг, мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх.

3.2. Улсын байцаагчийн үйл ажиллагаанд дараах үйлдэл, эс үйлдэхүйг хориглоно:

3.2.1. хүнд суртал гаргаж, иргэдийг чирэгдүүлэх, ажиллаж байгаа байгууллага, түүний удирдлага болон үйлчлүүлэгч, олон нийтийн хоорондын харилцаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аливаа үйлдэл хийх;

3.2.2. харьяалах нэгжийн даргын зөвшөөрөлгүйгээр өөрийн албан үүрэгт нөлөөлж болохуйц арга хэмжээнд оролцох, түүнчлэн аливаа хэлбэрийн шан харамж, бэлэг сэлт, шагнал урамшуулал авах, өөртөө болон гэр бүлийн гишүүддээ давуу байдал олж авах, хувийн чанартай хүсэлтийг үйлчлүүлэгчид тавих, үйлчлүүлэгчийн зардлаар аялах, амрах, дайлуулах, унаагаар нь үйлчлүүлэх, үйлчилгээ авах зэрэг хувийн харилцаа тогтоох;

3.2.3. албан үүргээ гүйцэтгэхдээ болон дүрэмт хувцастай байх үедээ согтууруулах ундаа, мансууруулах, танхайрах, бүдүүлэг зан авир гаргах зэргээр төрийн албан хаагчийн нэр хүндийг гутаах;

3.2.4. хяналт шалгалтын явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулах, нууц тоо, баримт, цахим мэдээллийн санг хувийн зорилгоор ашиглах, улсын байцаагчийн хэвлэмэл хуудас, хувийн тэмдэг болон хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг бусдад шилжүүлэх, ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;

3.2.5. Монгол Улсын хилээр гарахыг түдгэлзүүлсэн, албадан гаргасан гадаадын иргэнийг хилээр нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, нэвтрүүлэхэд оролцох;

3.2.6. улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдад нөлөөлөх, бусдын нөлөөнд автах, эрх мэдлээ урвуулан ашиглах, албан тушаалаа ашиглан бусдад дарамт, шахалт үзүүлэх;

3.2.7. хяналт шалгалтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дутуу хийх, шалгуулагч иргэн, хуулийн этгээдтэй үгсэн хуйвалдах, ая тал засах, зөрчил, түүний шалтгаан нөхцөл, нотлох баримт, гэм буруутай этгээдийг нуун дарагдуулах.

### **Дөрөв. Ёс зүйн дүрмийн биелэлтэд хяналт тавих, хүлээлгэх хариуцлага**

4.1. Улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд харьяалах нэгжийн дарга хяналт тавина.

4.2. Ёс зүйн зөрчил гаргасан улсын байцаагчийн зөрчлийн шинж байдлыг харгалзан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-д заасан ёс зүйн хариуцлага хүлээлгэнэ.

4.3. Ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй гэж үзвэл гомдол, мэдээлэл гаргасан иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэнэ.

4.4.Улсын байцаагчийг албан тушаал дэвшүүлэх, шагнаж урамшуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхдээ ёс зүйн хэм хэмжээг хэрхэн сахин биелүүлж байгааг харгалзан үзнэ.

4.5.Улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол эрх бүхий байгууллагад харьяаллын дагуу шилжүүлж шалгуулна.

#### **Тав.Бусад**

5.1.Улсын байцаагчийн сахилгын зөрчилтэй холбоотой асуудлыг Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулах, түүнд гомдол гаргах журам" болон бусад хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

---oOo---